

ТӨЛӨВЛӨГӨӨ

1. **СТАНЦЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**
 - 1.1 Төслийн нэр
 - 1.2 Төсөл хэрэгжүүлэгч
 - 1.3 Төслийн хүчин чадал
 - 1.4 Төслийн байршил
 - 1.5 Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил
2. **ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ**
 - 2.1 Төсөл хэрэгжих үеийн талбайн газрын эвдрэл, өөрчлөлт
3. **СТАНЦЫН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**
4. **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**
 - 4.1 Байгаль хамгаалах төлөвлөгөө
 - 4.2 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....
5. **СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**
6. **ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
7. **ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
8. **ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
9. **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**
10. **ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ**
11. **ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Станцын товч танилцуулга

“ДЦС-2” ТӨХК-ийн суурийг 1960 оны 3 сараас эхэлж 1961 оны 12 сарын 26 нд ашиглалтанд орж, 24 МВт цахилгаан эрчим хүч 67 Гкал дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадалтай ажиллаж байна.

Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 2.1 орчим хувийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний 2.1 орчим хувийг хангаж байна.

Станцын төрөл, ангилал: Хөндлөн холбоос бүхий 5 зуух, 3 турбинтэй цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх схемтэй;

- **Уурын генератор:**

- Цагт 75 тонн өндөр параметртэй (39 кгс/см², 440⁰С) уур үйлдвэрлэх хүчин чадалтай БКЗ-75-39Ф (ОХУ) маркийн 2 зуух
- Цагт 39 тонн өндөр параметртэй (39 кгс/см², 440⁰С) уур үйлдвэрлэх хүчин чадалтай ТС-35-39 (БНХАУ) маркийн 2 зуух;
- Цагт 39 тонн өндөр параметртэй (39 кгс/см², 440⁰С) уур үйлдвэрлэх хүчин чадалтай DHF 35-38.2 450 A1 (БНХАУ) маркийн 1 зуух;

- **Уурын турбин:**

- Цагт 6 МВт цахилгаан эрчим хүч, АК-6/35 маркийн турбин бол активны конденсационный турбин (БНХАУ) 1 турбин
- Цагт 6 МВт цахилгаан эрчим хүч, N6-3.43 маркийн турбин бол активны конденсационный турбин (БНХАУ) 1 турбин
- Цагт 12 МВт цахилгаан эрчим хүч, 76 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай АПТ12-35/10 (ОХУ) маркийн үйлдвэрийн болон дулаацуулгын (отбор) авлагатай 1 турбин,
 - **Турбогенераторын эргэлт:** 3000 эрг/мин;
Цахилгаан генераторын хүчдэл: 6000кВт, блок трансформаторын хүчдэл-110, 220кВт;
 - **Үндсэн түлш:** Б2 маркийн Багануур хүрэн нүүрс;
 - **Галлагааны түлш:** Дизель;
 - **Түлш зарцуулалт:** 1 уурын генератор цагт 75-80 тн бодит түлш;
 - **Түлш тээвэрлэлт:** төмөр зам;
 - **Нүүрс буулгах систем:** Нэг дор 12 вагон хүлээн авах өндөрлөгсөнд төмөр замтай 1 цагт 80 тн нүүрс тээвэрлэх 4 коннверттэй 80-105тн нүүрс бутлах 2ш бутлууртай
 - **Түлш, тос хадгалах нөөц:** 32000 тн нүүрс нөөцлөх ил талбай
 - **Үнс зайлуулах систем:** Нойтон, 1 км алслагдсан үнсэн сантай;
 - **Утааны хийг цэвэрлэх төхөөрөмж:** LCMD-1870 маркийн уутат фильтр бүтээмж 98-99%; 1 ширхэг баттериа циклон, бүтээмж 75%; 2 ширхэг нойтон үнс барих төхөөрөмж, бүтээмж 85%;
 - **Ус цэвэрлэх систем:** 6ш Фильтертэй
 - **Ус хангамж:** Аллювийн хурдасны уст үед байрлах ЭЦВ-10-120-60 маркын өргөх насосоор тоноглогдсон ашиглалтын 5 гүний худгаас одоогоор 1,2,3,4,5 гэсэн 5 гүний худгуудаас ус олборлон 300 м³, 400 м³- н багтаамжтай 2 усан санд хуримтлуулж үйл ажиллагаанд хэрэглэдэг.
 - **Утааны яндан:** Өндөр 100м, амсрын голч 5м, суурийн голч - 12м.

Үйлдвэрлэл, технологийн 4 цех, Техник бодлого, төлөвлөлт шуурхай ажиллагааны 1 алба, Хяналт техник аюулгүй ажиллагаа, Захиргаа удирдлага, Эдийн засаг, санхүү бүртгэл, худалдан авах ажиллагаа, Аж ахуйн гэсэн нийт 4 хэлтэс, эмнэлэг, зоогийн газар, авто аж ахуй, гэсэн нэгжийн зохион байгуулалттай үйл ажиллагааны холимог бүтэцтэй ажил үйлчилгээ явуулдаг.

2026 оны байдлаар нийт 285 ажиллагсадтай байгаагаас 56 ажилтан нь инженер техникийн ажилтан байна.

2001 оны 07 сараас 09 ний тогтолоор Төрийн өмчийн Хувьцаат Компани болж, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 10 дугаар сарын 31 ний өдрийн хуралдаанаар Төрийн өмчит компаниудын хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж байна.

2. Станцын талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

ДЦС-2 ТӨХК нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хороонд өөрийн байранд байрлана. Тус станцын харъяанд техникийн ус хангамжийн 5 гүний худаг, насос станц болон ахуй үйлчилгээний, инженерийн, лабораторийн зэрэг 34,15 га талбай бүхий 50 барилга байгууламж багтдаг.

Дулааны цахилгаан станц нь улс орны болон бүс нутгийн ашиг орлого, дэд бүтцийн хөгжлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Улсын төсөвт ашгийн татвар, хүн амын орлогын албан татвар, агаарын бохирдлын төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл, газар ашигласны төлбөр, ус ашигласны төлбөр ашиглахтай холбогдох татвар, төлбөрийг оруулдаг.

3. Станцын гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

3.1. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл

- Зуухны яндангаас ялгарч буй бохирдуулагч бодис
- Нүүрсний хадгалалт, буулгалтын үед нүүрсний жижиг хэсгүүд салхиар зөөгдөх
- Химийн бодисын ашиглалтын үед үүсэх хорт хий
- Үнсэн сан, үнс зайлуулах төхөөрөмж, зуухны орчимд ялгарч буй тоосжилт
- Дуу шуугиан, доргио чичиргээ
- Хөргөх цамхагаас үүсч буй усны уурын бохирдол

Нөлөөллийн эх үүсвэр

Дулааны цахилгаан станцын үйлдвэрлэлийн түүхий эд болох түүхий нүүрс, болон үнсэн сан, ус бэлтгэлд ашигладаг химийн бодис орно.

3.2. Хөрс, газрын гадаргад үзүүлж болзошгүй нөлөөлөл

Барилга байгууламж, хаягдлын хуримтлал болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох, хүн болон амьтдад аюултай нөхцөл, эрсдэл үүсгэх магадлалтай. Тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулах үйл ажиллагааны дараа бий болсон элэгдэл эвдрэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах,

тэдгээрээс бий болж болзошгүй бохирдлоос хамгаалах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Мөн түүний эргэн тойрны тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэлттай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, талхлагдах, ургамлан нөмрөг устгах, бүрхэц нь багасахын зэрэгцээ тоос, үйлдвэрийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдхүүнээр бохирдох нөлөөллүүд үүснэ.

Нөлөөллийн эх үүсвэр

Материал түүхий эд ачих, тээвэрлэх, үнсэн сан, химийн болон шатах тослох материалын агуулах, автомашины хөдөлгөөн, үйлдвэрийн технологийн болон ахуйн хаягдал, түүний байгууламж орно.

3.3. Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл

Газар доорхи усан орчин бохирдсон тохиолдолд хөрсөөр дамжин хүрээгээ тэлж, хүн, мал, амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө. Төсөл хэрэгжсэнээр гадаргын болон газрын доорхи усны хэрэглээг нэмэгдүүлснээр усны нөөц хомсдох, химийн бодис, урвалж агуулах боломжтой бохир ус хөрсөнд алдагдвал усан орчин бохирдоно.

Нөлөөллийн эх үүсвэр

- Хаягдлын болон нүүрсний овоолго
- Нефтийн бүтээгдхүүний буруу хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой осол
- Үнсэн сангийн шүүрэлт, сэтрэлт
- Химийн урвалж, бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалын гарч болзошгүй осол
- Үйлдвэрийн хаягдал болон ахуйн бохир усны шугам сүлжээний гэмтэл
- Гадаргын ус цуглуулах байгууламжид гарах эвдрэл, гэмтэл

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа 2023 оны байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян,төг/	Нийт зардал /мян,төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Агаар орчин						
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Төслийн хүрээнд	-	Урсгал зардал	Жилд нэг удаа	Агаарын тухай хууль, -MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3 16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) “Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” MNS 5078: 2001 стандартын шаардлагыг хангасан байх.
2		Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр түлш дамжуулах цехийн ажилчидыг хангах	Төслийн хүрээнд	-	ХАБ зардал	Жилд нэг удаа	
3		Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд			2-р улиралд	
4		Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий тоног төхөөрөмжийг ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Төслийн хүрээнд	600.0	600.0	2 цэгт Жилд 2 удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийнэ.	
5		Зуухнаас гарах дутуу шатлалтын үнснийг барих	Төслийн хүрээнд	-	ҮАЗ	Жилдээ	
Усны нөөц, чанар							
1	Ус ашиглах	Гүний худаг	Төслийн хүрээнд	--*--	--*--	Төслийн бүх үе шатанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2		Ус ашигласаны төлбөрийг төлөх, холбогдох ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	--*--	Тоолуурын заалтын дагуу	Жил бүр	Усны тухай хууль
Хөрс, ургамлан бүрхэвч							
1	Хөрс элэгдэл эвдрэлд орж	Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх,		--*--	ҮАЗ		- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

	үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх тоосжилтын улмаас хөрсөн бүрхэвч доройтох	талхлагдсан хөрсийг ургамалжуулах ажлыг хийж гүйцэтгэх					химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ - Хог хаягдлын тухай хууль Газрын тухай хууль Газар ашиглалтын тухай хууль
2		Хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх		ХХМ-д тусгав	-	Сар бүр	
3	Нийт дүн				600.0		

1.2 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян,төг/	Нийт зардал /мян,төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд Бүх ажилчдад	400.0	400.0	Сургалтыг жил бүрт 2 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1
2		Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	400.0	400.0		
3		Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	400.0	400.0		
4	Нийт дүн				1200.0		

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

1.3 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал /мян,төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хог хаягдлыг ангилан зориулалтын саванд цуглуулах, төвлөрсөн хогийн цэгт хаях	Үйл ажиллагааны турш	95.8	1150.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
2		Химийн аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй газраар устгуулах	Үйл ажиллагааны турш	-	1320.0	Жилдээ	
3		Эмнэлгийн хог хаягдлын ачилт, тээвэрлэлт, устгалд, аюулгүйн хайрцаг, уут устгуулах	Үйл ажиллагааны турш	-	1320.0	Жилдээ	
4		Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулах	Үйл ажиллагааны турш	-	ҮАЗ	Сар бүр	
5	Нийт дүн				3790.0		

1.4 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Өртөг /мян,төг/	Зардал /мян, төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ажиллагсдыг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны турш	--*--	--*--		
2	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагааны турш	800.0	800.0	Жил бүр	
3	Байгаль орчны аудитыг хийлгэх	Үйл ажиллагааны зардал	12,000.0	12,000.0	2 жил тутамд	
4	Нийт дүн			12,800.0		

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

1.5 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян,төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	мод, цэцэгжүүлэлт суулгац	Төслийн хүрээнд	3.000	Жил бүр	
2	Нийт дүн			3.000		

1.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ					
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцох талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлангах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан, ажилтан
БООЖА	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Жил бүр 1 удаа	-	-
БООУАӨЯ	Тайлан, төлөвлөгөөг цаасан, цахим хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Тухайн жилийн 11-12 сарын дотор	-	-

1.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Сар бүр ажиллагаанд байсан зуухнуудын утааны хийн найрлага дахь хорт бодисын хэмжилтийг үндэслэн массын болон эзэлхүүний агууламжийг тодорхойлсон. Хорт бодисуудын агууламжийг MNS 5919:2008 стандарттай харьцуулахад, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын исэл (NO_x), хүхрийн исэл (SO_x), дэгдэмхий үнсний хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал /мян,төг/	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO)	Төсөл хэрэгжиж байгаа газрын ойр	Төслийн талбай гадна автозамын	2,4-р улиралд	1.800	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

	шинжилгээ хийлгэж байх	орчимд тоосжилт үүсч, ажилчдад сөрөг нөлөө үзүүлэх	дэргэд, авто пүү, ажилчдын байрны дэргэд тус тус цэг сонгох			ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах			1.000	
1.3	Дуу шуугиан, чичиргээ	Тоног төхөөрөмжийн ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим 2 цэгт	2,4-р улиралд	--*--	
Усны хяналт шинжилгээ						
2.1	Гүний худаг	Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ус авдаг газраас	2,4-р улиралд	340.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS:13.060.50 Усны чанарын стандарт MNS:0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Хөрсний бохирдол						
3.1	Хөрсний морфологи бичиглэл, рН,	Хөрс элэгдэл эвдрэлд орох,	Талбайн гадна, хатуу хог	2,4-р улиралд	1.250	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO3, P2O5, K2O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	хаягдлын талбайн ойр тус бүр 1 цэг сонгох			тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт дүн				4,390	

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2026 оны зардлыг дараах хүснэгтэд харуулав

Д/д	Зардлын хэлбэр	Нийт зардал /мян,төг/
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	600
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	3000
3	Хог хаягдлал менежментийн төлөвлөгөөний зардал	3790
4	Осол, эрсдлийн төлөвлөгөөний зардал	1200
5	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	12800
6	БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	--*--
7	Орчны хяналт шинжилгээний зардал	4930
8	Нийт дүн	26,320

*“ДЦС-2”ТӨХК-ийн төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **хорин зургаан сая гурван зуун хорин мянган төгрөг** болж байна*

